



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 4/238

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэхь заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэр Баянгол 1 дүгээр гудамж 107 тоотод байрлах гэр, орон сууцны зориулалттай Дамдинжавын Лхагвасүрэнгийн /пя66090717/ 831.0 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу "Сацгурван хайрхан" ХХК /8093474/ орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02.01.2019
D/Zax-A/238-Da